

Огноо: 2025.02.14

№ 32

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Банкны тухай хуулийн 35.3 дугаар хэсэг, “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.13.7 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, “Төрийн банк” ХК-ийн Ногдол ашгийн бодлогыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсүгэй.

2. “Төрийн банк” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангаарх татварын дараах цэвэр ашгаас нийт эргэлтэд байгаа 755,096,250 (долоон зуун тавин таван сая ерэн зургаан мянга хоёр зуун тавь) ширхэг хувьцаанд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.

3. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн дүнг 63.70 (жаран гурван төгрөг далан мөнгө) төгрөг байхаар тогтоосугай.

4. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

5. Ногдол ашгийг эрх бүхий зохицуулагч байгууллагын зөвшөөрлийг хүлээн авсны үндсэн дээр 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан олгохыг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.

6. Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.

7. Тогтоолын хувийг Монголбанканд хүргүүлж ногдол ашиг хуваарилах зөвшөөрөл авах, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-д тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.

8. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд тайлагнахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга (Б.Тэлмүүн)-д үүрэг болгосугай.

9. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Б.Болор-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН